


**ТОЙОТА МӨРӨӨДЛИЙН МАШИН**

\* НАСНЫ АНГИМ: 7 НАС ХҮРТЭЛ \* 8-11 НАС \* 12-15 НАС

\* БҮТЭЛ ХҮЛЭЭЖ ЖЕЛЭХ ХУГАЦАА: 2022.12.31 - НИМ, 12-15 НАС \* 23:59 ЦАГ ДУУСЛАМ



TOYOTA



## БҮТЭЭЛД ТАВИХ ШААРДЛАГА

- ★ Мөрөөдлөө биелүүлэхэд тань туслах машиныг зөвхөн өөрийн сэтгэмжээр төсөөлөн зурсан байх.
- ★ Өөрийн бүтээлийн санааг товч илэрхийлсэн нэр өгсөн байх.
- ★ Өнгө, будгийн бүх төрлийн хэрэгсэл ашиглаж болно.
- ★ Энэ жил дижитал арт бүтээлүүдийг хүлээн авч буйгаараа онцлогтой.
- ★ Хар, цагаан буюу зураасан зургийн ажилбар хүлээн авахгүй.
- ★ Бусадтай хамтран зурсан бүтээлийг хүлээн авахгүй.
- ★ Зохиогчийн эрхийг зөрчөөгүй, бусдын оюуны өмчийг ашиглаагүй байх.

★ Тухайлбал Disney-н үлгэрийн баатруудыг зурахаас татгалзах

- ★ Өмнөх онуудын "Тоёота Мөрөөдлийн машин" гар зургийн уралдааны оролцогчдын болон бусад алдартай бүтээлүүдийг дуурайхгүй байх.





## БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВАХ

- ★ Бүтээлийг зөвхөн онлайнаар бүртгэнэ.
- ★ Бүртгэлийг <http://dcac.toyota-mongolia.mn/> вебээр хийх бөгөөд бүртгэлийн маягт хэсгийг бүрэн бөглөсөн байна.
- ★ Бүтээл, гар зургийнхаа фото зургийг авч бүтээл оруулах хэсэгт оруулна.
  - ★ Фото зурагт нэг л бүтээлийг бүтнээр нь багтаан дарсан байх
  - ★ Гэрэлтүүлэг сайн орчинд зураг дарсан байх (байгалийн гэрэл)
  - ★ Дарсан зураг 4:3 харьцаатай байх (босоо, хөндлөн хамаагүй)
  - ★ Зургийн нягтаршил 2880\*2160 pixels –с багагүй байх
  - ★ Зургийн хэмжээ 3 мв-ээс хэтрэхгүй байх
  - ★ Jpg, bmp болон зургийн форматтаар дарсан байна.
- ★ Зураг зурж байх үеийн бичлэгээ 1 минутад багтаан хийж, бичлэг оруулах хэсэгт оруулна.
  - ★ Бичлэгийн хэмжээ 10МБ-аас хэтрэхгүй
  - ★ Mov, mp3 зэрэг бичлэгийн форматтай байна.

ЖИЧ:

Цахимаар ирүүлсэн зургийн өнгө, гэрэл зөрүүтэй байх, бараан харанхуй байх, томруулж үзэхэд бүрсгэр байх зэрэг чанарын шаардлага хангаагүйгээс болж шүүлтийн явцад сул тал үүсэх эрсдэлтэй тул аль болох гэрэлтүүлэгтэй орчинд авсан байхыг зөвлөе.

Мөн цахимаар ирүүлсэн хуулбар зураг шилдгээр шалгарсан тохиолдолд бүтээлийн эх хувьтай харьцуулан баталгаажуулах болохыг анхаараарай



## ШАЛГАРУУЛАЛТ

- ★ Уралдааныг хамтран зохион байгуулагч "Монгол Контент" ХХК нь "Мөрөөдлийн машин" гар зургийн уралдааны материалуудыг нэгтгэж, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн хөндлөнгийн багаар шүүлт хийлгэн 3 насны ангилалд тус бүр 3 шилдэг бүтээл, нийт 9 шилдэг бүтээлийг шалгаруулна.
- ★ Уралдааны ерөнхий зохион байгуулагч "Тоёота" брэнд нь уралдааныг шилдэг 9 бүтээлээс шилдгийн шилдэг 1 бүтээлийг шалгаруулна.

Уралдааны шилдэг оролцогчийг шалгаруулахдаа зөвхөн ур чадвар бус бүтээлийн эх санааг чухалд харгалзан үзэж шалгаруулна.

## ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

### Агуулга:

- ★ Тухайн бүтээл ирээдүйн өөрчлөлт рүү чиглэсэн оролцогчийн хүсэл мөрөөдлийг илэрхийлж чадаж байгаа эсэх
- ★ Бүтээлд ямар нэгэн сэтгэл хөдлөл, хайр энэрэл, хүчтэй санаа тусгасан эсэх
- ★ Бүтээлд тусгасан агуулга, санаа нь хүүхдийн хүсэл мөрөөдлийг биелүүлэхүйц илэрхийлэмж мөн эсэх

### Дахин давтагдашгүй:

- ★ Хүсэл мөрөөдөл нь шинэлэг, хүүхдийн санаа анхдагч болж чадаж байгаа эсэх

### Уран сайхны чанар:

- ★ Бүтээлийн зохиомж, өнгө техник зэрэг нь зөв зохистой, тохиромжтой эсэх

## Шагнал гардуулах

- ★ 2023 оны 01 дүгээр сарын 04 -нд шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулна. Шалгарсан шилдэг 9 бүтээлийн эзэнтэй урьдчилан цаг товлосны дагуу холбогдон шагналыг хүргүүлнэ.

★ Холбоо барих: 7555-3131, 9588-8630

